



МОНГОЛ УЛСЫН
ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН
ГИШҮҮНИЙ ЗӨВЛӨМЖ

2023 оны 01 дугаар сарын 17

№ 05/05

Улаанбаатар хот

АЙМГИЙН ХӨДӨЛМӨР,
ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГА ТАНАА

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.11, мөн хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.6, 29 дүгээр зүйлийн 29.6.4 дэх заалтыг тус тус үндэслэн > аймгийн сум дахь Говийн бүсийн ахмад настны төрөлжсөн асрамжийн газрын асруулагчдын эрхийн хэрэгжилтэд 2022 оны 11 дүгээр сарын 03, 04-ний өдрүүдэд хяналт шалгалтыг зохион байгууллаа.

Хяналт шалгалтыг холбогдох баримт бичигт дүн шинжилгээ хийх, нөхцөл байдалтай газар дээр нь танилцах, тус газрын албан хаагчид болон асруулагчидтай ганцаарчилсан ярилцлага хийх, холбогдох албан тушаалтнаас тайлбар авах зэрэг аргачлалаар явуулахад дараах нөхцөл байдал тогтоогдож байна. Үүнд:

1. Тус газрын барилга нь 70 жил ашиглагдаж байгаа бөгөөд барилгын үндсэн хийцүүд элэгдэлд орж бетон хаяавч эвдэрч суурь руу гадаргын ус орох нөхцөл бүрдсэн, даацын болон даацын бус хананд нэвт цууралт үүссэн, ханын чулуу унаж гадна шавардлага нурж өнгө үзэмжээ алдсан, модон хучилтын шавардлага дүүжин таазан дээрээс нурсан, модон рамтай цонхнуудын битүүмжлэл алдагдсан, модон шал эвдэрч овон товон үүссэн, хурын ус нэвчиж өрөө тасалгааны хана таазны будаг эмульс, шавар ховхорч чийгшил үүсэж хөндийрсөн, шавардлагын завсар тоос шороо хуримтлагдаж дулаан алдагдан хүйтэн агаар орж хана таазны уулзвар, булангийн хэсгээр цан цохисон, мөөгөнцөр их хэмжээгээр үүссэн байгаа нь эрүүл мэндэд сөрөг нөлөө үүсгэхээр байх төдийгүй, албан хаагчид, ажилтнуудын ажиллах болон асруулагчдын амьдрах нөхцөл аюулгүй байдал хангагдаагүй эрсдэлтэй байна.

аймгийн Мэргэжлийн хяналтын газраас “Барилгын ашиглалт, чанарын төлөв байдлын тухай” 2011 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 38/24-26 дугаар дүгнэлтээр “их засварын ажлыг хийх шаардлагатай”, 2018 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 11-7-39/153 тоот дүгнэлтээр “уг барилгыг буулгах, шинэчлэн засварлалт хийх арга хэмжээг авч хүний амьдрах, ажиллах таатай нөхцөлийг хангах шаардлагатай” гэж тус тус дүгнэсэн байна.

Тус газар нь шинэ байр бариулахаар гүйцэтгэгч компанитай 2022 оны 02 дугаар сард гэрээ байгуулсан байх бөгөөд 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдөр ашиглалтад орохоор гэрээнд заасан байх боловч барилгын гүйцэтгэл нь 50-60 хувьтай байгаа тухай ахлах мэргэжилтэн тайлбарлажээ.

2. Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2013 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн А/156 дугаар тушаалаар Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа ахмад настан, 18 ба түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тэтгэвэр олгох журмын 2.7-д “Төрөлжсөн асрамжийн газарт асруулж байгаа иргэн нь банкнаас өөрийн биеэр очиж тэтгэврээ авах боломжгүй бол асрамжийн газрын итгэмжлэгдсэн төлөөлөгч авна.” гэж заасан боловч асруулагчдыг тэтгэвэр, тэтгэмжээ авах боломжтой эсэхийг хүн тус бүрээр тогтоосон баримтгүйгээр асруулагч нэг бүрд итгэмжлэл хийлгэсэн

D:\2023 on\A4.month1.docx

• 150070005

байна. Асруулагчдын тэтгэвэр, тэтгэмжийг тус байгууллагын нярав [redacted] 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр нотариатаар баталгаажуулсан итгэмжлэлээр авч байх боловч тус ажилтан 2022 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр нярвын албан тушаалт томилогдсон байна. Нярав [redacted] нь асруулагчдын тэтгэвэр, тэтгэмжийг банкнаас хүлээн аваад зарцуулалт хийхгүйгээр нийгмийн ажилтан [redacted] хүлээлгэн өгдөг байх бөгөөд тэрээр асруулагчдын өргөн хэрэглээний барааны захиалгыг амаар хүлээн авч худалдан авалт хийдэг, эмч [redacted] асруулагчдын картыг баримтгүйгээр дамжуулан тэдний эм, эмчилгээний бүтээгдэхүүнийг үйлчлүүлэгч тус бүрийн картаар худалдан авалт хийдэг боловч асруулагчдад үнийн мэдээлэл болон худалдан авсан зүйлээ хүлээлгэн өгсөн талаар баримт үйлддэггүй байна.

3. Тус газрын камерын хяналтын дэлгэцийг нийгмийн ажилтны өрөөнд байрлуулсан ба дотоод журамд хяналтын системийн техник, хэрэгсэлд хяналт тавих, ашиглах талаар зохицуулаагүй, камерын бичлэгтэй хэн, ямар зорилгоор танилцсан талаарх бүртгэл, тэмдэглэл хөтөлдөггүй болох нь шалгалт болон нийгмийн ажилтны гаргасан тайлбараар тус тус тогтоогдож байна. Иймд хяналтын камерыг ашиглахтай холбоотой асуудлыг холбогдох журмаар зохицуулах, хяналтын дэлгэцийг зөвхөн хариуцсан ажилтанд харагдахуйц байдлаар байрлуулж асруулагчдын халдашгүй чөлөөтэй байх, хувийн нууцтай байх эрхийг хангах шаардлагатай байна.

4. Говийн бүсийн Ахмад настны төрөлжсөн асрамжийн газарт эрэгтэй 7, эмэгтэй 6 нийт 13 иргэн асрамжийн үйлчилгээ авч байна. Асруулагчдын дэлгэрэнгүй судалгаанаас үзэхэд 13 асруулагчаас сэтгэцийн эмгэгтэй 1, оюуны хомсдолтой 1, сэтгэлзүйн уналтад орсон 1 иргэн байна. Иймд тус төвөөс сэтгэцийн эмгэгтэй асруулагчдыг Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 141 дүгээр зүйлийн 141.1 дэх хэсэгт заасны дагуу ... сэтгэцийн өвчний улмаас иргэний эрх зүйн чадамжгүй гэж тооцуулах тухай хүсэлтийг мөн зүйлийн 141.2 дахь хэсэгт заасны дагуу оршин суугаа буюу эмчлүүлж байгаа газрын шүүхэд гаргаж, сэтгэцийн эмгэг судлалын шинжээч томилон шинжилгээ хийлгүүлж, тухайн иргэний сэтгэцийн байдал, өөрийн үйл ажиллагааны учир холбогдлыг ойлгох, өөрийгөө зөв удирдаж чадах эсэх талаар дүгнэлт гаргуулж, харгалзан дэмжилт, асран хамгаалалтыг тогтоолгох шаардлагатай байна.

5. Тус газар нь батлагдсан огноо нь тодорхойгүй "Үйлчлүүлэгчдийн дотоод журам"-ыг мөрдөн ажиллаж байх бөгөөд тус журмын 5-д "Үйлчлүүлэгч нь хуваарийн дагуу үүдний жижүүрт гарч байх" талаар зохицуулсан байх бөгөөд асруулагчдад тавих хяналт, аюулгүй байдлыг хэн, хэрхэн хангахыг зохицуулаагүй байна.

Иймд дээрх хяналт шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдлыг үндэслэн Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3 дахь хэсэгт заасны дагуу дараах Зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. Говийн бүсийн Ахмад настны төрөлжсөн асрамжийн газрын шинээр баригдаж байгаа байрыг төлөвлөсөн хугацаанд ашиглалтад оруулах талаар боломжит бүхий л арга хэмжээг авч асруулагчдын ая тухтай амьдрах нөхцөл боломжийг хангах;

2. Асруулагч банкнаас өөрийн биеэр очиж нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг авах боломжтой эсэхийг хүн тус бүрээр тогтоох, асруулагчдын картыг баримтгүйгээр бусдад шилжүүлэхгүй байх, асруулагч нэг бүрийн зөвшөөрлөөр итгэмжлэл хийж нотариатаар батлуулах, итгэмжлэгдсэн этгээд асруулагчдын захиалгын дагуу авчирсан эд зүйлээ хүлээлгэн өгсөн тухай бүртгэл хөтөлж, нотлох баримтыг хавсаргах асуудлыг журамлах, энэ талаар хяналт тавих;

3. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.10 дахь хэсэгт зааснаар хяналтын камерыг мэдээлэлд хандах эрхгүй этгээд хандахаас урьдчилан сэргийлэх техникийн болон үйл ажиллагааны нөхцөлийг бүрдүүлж журамлах, хяналтын дэлгэцийг зөвхөн хариуцсан ажилтанд харагдахуйц байдлаар байршуулах,

асруулагчдын хувийн мэдээллийг хамгаалах талаар холбогдох хуульд заасан зохион байгуулалтын арга хэмжээ авах;

4. Сэтгэцийн эмгэгтэй асруулагчдыг Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 141 дүгээр зүйлийн 141.1 дэх хэсэгт заасны дагуу сэтгэцийн өвчний улмаас иргэний эрх зүйн чадамжгүй гэж тооцуулах тухай хүсэлтийг мөн зүйлийн 141.2 дахь хэсэгт заасны дагуу оршин суугаа буюу эмчлүүлж байгаа газрын шүүхэд асран хамгаалах байгууллага гаргаж, сэтгэцийн эмгэг судлалын шинжээч томилон шинжилгээ хийлгүүлж, тухайн иргэний сэтгэцийн байдал, өөрийн үйл ажиллагааны учир холбогдлыг ойлгох, өөрийгөө зөв удирдаж чадах эсэх талаар дүгнэлт гаргуулж, харгалзан дэмжигч, асран хамгаалалтыг шүүхээр тогтоолгох;


5. Говийн бүсийн Ахмад настны төрөлжсөн асрамжийн газрын Асруулагчдын дотоод журмыг Ахмад настны тухай хууль болон холбогдох бусад хуульд нийцүүлэн шинэчлэн батлах;

6. Говийн бүсийн Ахмад настны төрөлжсөн асрамжийн газрын албан хаагчдыг хүний эрхийн мэдлэг ойлголт түгээх болон ахмадын асрамж үйлчилгээтэй холбоотой сургалтад хамруулах арга хэмжээ авах;

Зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт, үр дүнг холбогдох баримтын хамт Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсэгт зааснаар 30 хоногийн дотор хариу ирүүлнэ үү.

Хувийг: _____ аймгийн _____ сум дахь Говийн бүсийн ахмад настны төрөлжсөн асрамжийн газарт

ГИШҮҮН



Д.СҮНЖИД